



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/101/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2-10
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4-5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7-8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8-9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12-13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13-14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14-15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16



ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Г.НЯМХАНД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>Төгрөгөөр</i>			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	95,442,890.00	117,390,085.00
33	АВЛАГА	1,539,900.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,539,900.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	93,902,990.00	117,390,085.00
351	Түүхий эд материал	2,915,600.00	6,387,650.00
35110	Тусгай зориулалттай материал	2,915,600.00	6,387,650.00
354	Хангамжийн материал	87,119,390.00	107,752,435.00
35410	Бичиг хэргийн материал	368,500.00	721,500.00
35420	Аж ахуйн материал	11,319,878.00	13,476,148.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	4,015,700.00
35450	Барилгын засварын материал	236,400.00	236,400.00
35470	Бусад хангамжийн материал	75,194,612.00	89,302,687.00
35600	Мал амьтад	3,868,000.00	3,250,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	525,836,191.71	891,745,990.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	525,836,191.71	891,745,990.74
392	Биет хөрөнгө	498,568,644.45	861,892,193.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	389,523,372.00	586,012,076.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-191,015,775.42	-130,690,975.93
39203	Авто-тээврийн хэрэгсэл	110,617,300.00	100,565,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-47,924,604.96	-38,333,398.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	113,162,670.75	165,445,988.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-62,469,558.87	-44,028,456.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,546,521.76	29,982,340.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,734,007.32	-9,490,530.37
39209	Зам, гүүрийн байгууламж	285,817,677.04	330,780,254.91
39210	Хуримтлагдсан элэгдэл	-136,314,549.69	-151,721,481.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	52,237,400.08	50,722,500.04
39215	Хуримтлагдсан элэгдэл	-24,877,800.92	-27,351,925.04
393	Биет бус хөрөнгө	27,267,547.26	29,853,797.26
39301	Програм хангамж	4,297,000.00	2,680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,203,250.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	27,173,797.26	27,173,797.26
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	621,279,081.71	1,009,136,075.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,774,593.00	7,200,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,774,593.00	7,200,000.00
413	Өглөг	2,774,593.00	7,200,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,406,133.00	00.00
4136	Бусад өглөг	1,368,460.00	7,200,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,368,460.00	7,200,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	618,504,488.71	1,001,936,075.74
51	Засгийн газрын хувь оролцоо	618,504,488.71	1,001,936,075.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	415,830,761.84	415,830,761.84
51101	Өмч: - төрийн	415,830,761.84	415,830,761.84
512	Хуримтлагдсан үр дүн	80,264,248.88	466,751,731.91
51210	Өмнөх үеийн үр дүн	80,264,248.88	159,084,120.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	307,667,611.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	122,409,477.99	119,353,581.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	621,279,081.71	1,009,136,075.74



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	425,247,726.00	771,491,240.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,301,653.00	362,698,457.00
120	Нийтлэг татварын бус орлого	69,301,653.00	362,698,457.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,301,653.00	356,341,257.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,500.00	240,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	68,234,153.00	00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө		355,101,257.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал		6,357,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	355,946,073.00	408,792,783.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,888,073.00	10,702,583.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,106,646.00	500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	370,000.00	7,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,886,427.00	1,462,583.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	525,000.00	3,279,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	344,058,000.00	398,090,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	344,058,000.00	398,090,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	437,842,475.16	460,573,628.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,842,475.16	460,573,628.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,726,359.82	440,279,855.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,143,872.52	252,317,615.96
210101	Үндсэн цалин	238,283,872.52	252,317,615.96
210105	Гэрээт ажлын хөлс	860,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,309,400.00	33,609,841.37
210201	Тэтгэврийн даатгал	22,768,000.00	23,516,734.97
210202	Тэтгэмжийн даатгал	2,385,300.00	2,523,101.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,908,300.00	2,018,481.23
210204	Ажилгүйдлийн даатгал	477,100.00	504,620.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4,770,700.00	5,046,903.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,963,956.64	30,154,713.83
210301	Гэрэл, цахилгаан	2,103,590.64	2,068,246.83
210302	Түлш, халаалт	22,860,366.00	28,086,467.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,971,735.40	19,980,871.00
210401	Бичиг хэрэг	1,842,658.00	3,015,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,691,261.40	10,458,427.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,085,216.00	2,709,974.00
210404	Ном, хэвлэл	532,000.00	46,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,244,500.00	2,056,920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,576,100.00	1,694,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,914,960.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	3,914,960.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	431,000.00	900,000.00
210702	Дотоод албан томилолт	431,000.00	900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,924,489.00	6,904,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,982,257.00	5,963,400.00



210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	172,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,832.00	132,674.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	170,500.00	478,500.00
210807	Газрын төлбөр	00.00	69,486.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,066,946.26	91,412,013.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,078,176.50	13,234,880.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,988,769.76	78,177,133.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,116,115.34	20,293,772.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,064,195.00	11,636,706.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	9,863,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,064,195.00	1,272,906.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,051,920.34	8,657,066.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,051,920.34	8,657,066.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-12,594,749.16	310,917,611.83
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,547,000.00	3,250,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,547,000.00	3,250,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,547,000.00	-3,250,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-14,141,749.16	307,667,611.83



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			<i>Төгрөгөөр</i>	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	357,013,573.00	411,572,683.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,067,500.00	1,240,000.00	
120	Нийтлэг татварын бус орлого	1,067,500.00	1,240,000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,067,500.00	1,240,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,500.00	240,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	355,946,073.00	410,332,683.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,888,073.00	12,242,483.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,106,646.00	500,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	370,000.00	7,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,886,427.00	1,462,583.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	525,000.00	3,279,900.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	344,058,000.00	398,090,200.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	344,058,000.00	398,090,200.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	357,013,573.00	398,350,983.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,013,573.00	398,350,983.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	345,397,457.66	378,057,210.16	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,143,872.52	252,357,515.96	
210101	Үндсэн цалин	238,283,872.52	252,357,515.96	
210105	Гэрээт ажлын хөлс	860,000.00	00.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,309,400.00	33,609,841.37	
210201	Тэтгэврийн даатгал	22,768,000.00	23,516,734.97	
210202	Тэтгэмжийн даатгал	2,385,300.00	2,523,101.60	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,908,300.00	2,018,481.23	
210204	Ажилгүйдлийн даатгал	477,100.00	504,620.37	
210205	Эрүүл мэндийн даатгал	4,770,700.00	5,046,903.20	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,620,358.64	30,154,713.83	
210301	Гэрэл, цахилгаан	2,103,590.64	2,068,246.83	
210302	Түлш, халаалт	24,516,768.00	28,086,467.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	22,758,294.50	25,673,195.00	
210401	Бичиг хэрэг	2,773,978.00	3,388,000.00	
210402	Тээвэр, шатахуун	14,033,116.50	14,474,126.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,033,700.00	3,079,049.00	
210404	Ном, хэвлэл	548,000.00	46,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,244,500.00	2,056,920.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,125,000.00	2,628,600.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	6,790,000.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	80,000.00	
210602	Тавилга	00.00	1,710,000.00	
210604	Урсгал засвар	2,000,000.00	5,000,000.00	
2107	Томилолт, зочны зардал	622,000.00	900,000.00	
210702	Дотоод албан томилолт	622,000.00	900,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,569,032.00	13,671,944.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,147,300.00	12,650,544.00	



210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	172,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,832.00	132,674.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	650,000.00	558,500.00
210807	Газрын төлбөр	00.00	69,486.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,374,500.00	14,900,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,374,500.00	14,900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,616,115.34	20,293,772.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,024,295.00	11,636,706.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	9,863,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,024,295.00	1,272,906.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,591,820.34	8,657,066.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,591,820.34	8,657,066.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	13,221,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	13,221,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	13,221,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	13,221,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	13,221,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-13,221,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	399,090,200.00	390,673,133.16	8,417,066.84	97.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,090,200.00	390,673,133.16	8,417,066.84	97.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	388,226,400.00	379,809,333.16	8,417,066.84	97.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,855,200.00	252,317,615.96	537,584.04	99.8
210101	Үндсэн цалин	252,855,200.00	252,317,615.96	537,584.04	99.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,033,700.00	33,609,841.37	423,858.63	98.8
210201	Тэтгэврийн даатгал	23,746,000.00	23,516,734.97	229,265.03	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,571,900.00	2,523,101.60	48,798.40	98.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,057,500.00	2,018,481.23	39,018.77	98.1
210204	Ажилгүйдлийн даатгал	514,400.00	504,620.37	9,779.63	98.1
210205	Эрүүл мэндийн даатгал	5,143,900.00	5,046,903.20	96,996.80	98.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,727,800.00	30,154,713.83	2,573,086.17	92.1
210301	Гэрэл, цахилгаан	2,925,800.00	2,068,246.83	857,553.17	70.7
210302	Түлш, халаалт	29,802,000.00	28,086,467.00	1,715,533.00	94.2
2104	Хангамж, бараа материалын зардал	19,651,100.00	16,695,518.00	2,955,582.00	85.0
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	9,622,500.00	7,884,449.00	1,738,051.00	81.9



210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,100,000.00	3,079,049.00	20,951.00	99.3
210404	Ном, хэвлэл	300,000.00	46,500.00	253,500.00	15.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	56,920.00	943,080.00	5.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,628,600.00	2,628,600.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,501,300.00	19,501,300.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
210602	Тавилга	10,501,300.00	10,501,300.00	-	100.0
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	935,800.00	900,000.00	35,800.00	96.2
210702	Дотоод албан томилолт	935,800.00	900,000.00	35,800.00	96.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,621,500.00	11,730,344.00	1,891,156.00	86.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,615,500.00	10,708,944.00	906,556.00	92.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00	540,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	172,740.00	27,260.00	86.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	132,674.00	17,326.00	88.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	88,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	835,800.00	558,500.00	277,300.00	66.8
210807	Газрын төлбөр	192,200.00	69,486.00	122,714.00	36.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14900000.00	14900000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,900,000.00	14,900,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10863800.00	10863800.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,863,800.00	10,863,800.00	-	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,863,800.00	9,863,800.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	399,090,200.00	390,673,133.16	8,417,066.84	97.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	358,079,200.00	389,433,133.16	(31,353,933.16)	108.8
132001	Орон нутгийн төсвөөс	358,079,200.00	389,433,133.16	(31,353,933.16)	108.8
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			-	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	41,011,000.00	1,240,000.00	39,771,000.00	3.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		240,000.00	-240,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	40,011,000.00	00.00	40,011,000.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	08.00	08.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	-	100.0
620004	Гэрээт ажилтан	04.00	04.00	-	100.0



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

<i>Төгрөгөөр</i>		
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,242,483.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,242,483.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,469,577.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,900.00
210101	Үндсэн цалин	39,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,977,677.00
210401	Бичиг хэрэг	388,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,589,677.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,452,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,452,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	772,906.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	772,906.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	772,906.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12242483.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,242,483.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,462,583.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,279,900.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газартай шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулж байх болон өр төлбөр үүсгэхгүй ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 3/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг иргэдэд хүргэх, төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.



3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 302.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өмнөх оны авлагын үлдэгдэл болох 1.5 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг барагдуулсан бөгөөд тайлант онд авлага үүсээгүй байна.

Өмнөх оны өр төлбөрийн үлдэгдэл 2.8 сая төгрөгийг барагдуулсан хэдий ч тайлант онд 7.2 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 93.9 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 105.4 сая төгрөг болж 11.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын материал, түлш шатах тослох материал, бусад хангамжийн материал зэрэг данснуудын материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй болбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 525.8 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 891.7 сая төгрөг болж өссөн байна. Энэ нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 13.2 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж болон үнэ төлбөргүй хүлээн авсан 355.1 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн тухайд нийт орлого өмнөх онд 357.0 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 411.6 сая төгрөг болж 54.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тус байгууллагын санхүүгийн тайлангийн тодруулгад тайлант онд үүссэн өр, авлага, үндсэн хөрөнгө, бараа материал болон мөнгөн хөрөнгө, төсвийн гүйцэтгэлийн талаарх бүхий л мэдээллийг бүрэн тусгасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны төсвийн төслийг 499.6 сая төгрөгөөр төлөвлөн боловсруулж төсвийн саналаа тус сумын төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэн нэгтгүүлсэн бөгөөд төсвийг анх 349.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 349.9 сая төгрөгийн төсөв баталсан бөгөөд тодотголоор 49.2 сая төгрөгийн төсвийг нэмж баталсан бөгөөд 358.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс 1.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос 40.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төсөвт өөрчлөлт оруулан баталсан байна.



Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 358.1 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 1.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.2 сая төгрөг, нийт 399.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 390.7 сая төгрөгийг зарцуулж 8.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Бараа үйлчилгээний зардалд 379.8 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 10.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 97.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3.3 сая төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас мал тооллогын зардалд 1.2 сая төгрөг, хамтарсан багийн зардалд 0.3 сая төгрөг, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 2.0 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 5.0 сая төгрөг, хандив тусламжаар 0.5 сая төгрөг авч нийт 12.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас бараа үйлчилгээний зардалд 11.5 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 0.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар асуудлыг онцолсон хэсэг байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага:

- Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
- Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.
- Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

3.8 Аудитын гол асуудал

Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын байрны их засварын ажлын зураг төсвийг 12.0 сая төгрөгөөр хийлгэсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөс 2020 онд 2.3 сая төгрөгийг, Засаг даргын Тамгын газрын төсвөөс 2021 онд 2.5 сая төгрөгийг тус тус төлсөн бөгөөд их засварын ажлын төсвийн санхүүжилт батлагдаагүй байна.

Тус байгууллага нь 2021 оны байдлаар их засварын ажлын зураг төсвийн үнийн үлдэгдэл болох 7.2 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.



3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төмөрбулаг сумын ЗДТГ нь 2021 онд нийт 458.1 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас таван сая төгрөгөөс дээш дүнтэй орлого зарлагын 301.7 сая төгрөгийн 19 мэдээллийг мэдээлээгүй, 46.5 сая төгрөгийн тендерийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээний хэрэгжилт баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 177.4 сая төгрөгийн 5 алдаа, 7.2 сая төгрөгийн 1 зөрчил илэрснээс аудитын хугацаанд 177.4 сая төгрөгийн 5 алдааг залруулж 7.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 348.2 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 177.4 сая төгрөгийн залруулгыг хийсэн. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 13.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн гүйлгээг бүртгэхдээ мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд бүртгүүлсэн.

Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа үнийн зөрүү дансанд бүртгэсэн 32.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгасан хөрөнгө дансанд бүртгүүлсэн.

Элэгдэл нь буруу бодогдсон үндсэн хөрөнгүүд данснаас хасаж буцаан орлого авсан байсныг орлого зарлагын гүйлгээг нь устгуулж өмнөх үеийн үр дүнд байвал зохих элэгдлийн зардлын дүнгээр нь залруулах бичилт хийлгэсэн.

Тус байгууллагын их засварын ажлын 12.0 сая төгрөгийн өртөгтэй зураг төсвийг орлогод аваагүй байсныг бараа материалын дансанд орлогоор бүртгүүлсэн.



Тус байгууллагын их засварын ажлын зураг төсвийн төлбөрийн үлдэгдэл 7.2 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгэлд тусгаагүй байсныг тус тус залруулсан.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны байдлаар байгууллагад төлөх 7.2 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт хэрэгжүүлж ажиллах.

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төмөрбулаг сумын ЗДТГ нь 2021 онд нийт 458.1 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас таван сая төгрөгөөс дээш дүнтэй орлого зарлагын 301.7 сая төгрөгийн 19 мэдээллийг мэдээлээгүй, 46.5 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төмөр булаг сумын ЗДТГ Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой	6	184.6	5	177.4					1	7.2
2	Төмөр булаг сумын ЗДТГ Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой	21	348.2							1	348.2
Дүн		27	532.8	5	177.4					2	355.4

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО:



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						<i>Төгрөгөөр</i>
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	122,409,477.99	80,264,248.88	00.00	618,504,488.71
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	122,409,477.99	80,264,248.88	00.00	618,504,488.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	78,819,871.20	00.00	78,819,871.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	415,830,761.84	122,409,477.99	159,084,120.08	00.00	697,324,359.91
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-3,055,896.00	00.00	00.00	-3,055,896.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	307,667,611.83	00.00	307,667,611.83
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,830,761.84	119,353,581.99	466,751,731.91	00.00	1,001,936,075.74